



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Сайнцагаан сумын Говийн ирээдүй цогцолбор сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ДУА-2022/57/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Мандалговь хот

2022 он

Аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох

Утас: 70592439

Цахим хаяг: [Munkhtogtokhr@audit.gov.mn](mailto:Munkhtogtokhr@audit.gov.mn)

Аудитын менежер: Х.Наранцацрал

Утас: 70592225

Цахим хаяг: [Narantsatsralkh@audit.gov.mn](mailto:Narantsatsralkh@audit.gov.mn)

Ахлах аудитор: Т.Батсайхан

Утас: 70593113

Цахим хаяг: [Batsaikhant@audit.gov.mn](mailto:Batsaikhant@audit.gov.mn)

Аудитор: Д.Должинсүрэн

Утас: 70593113

Цахим хаяг: [Doljinsuren@audit.gov.mn](mailto:Doljinsuren@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

.....	0
1.Аудитын санал дүгнэлт .....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. Аудитын тайлан .....	14
3.1 Ерөнхий зүйл .....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	14
3.4 Материаллаг байдал .....	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	16
3.8 Аудитын гол асуудал .....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт.....	18
4.1 Залруулсан алдаа.....	18
4.2 Төлбөрийн акт.....	18
4.3 Албан шаардлага.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	19

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум  
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,  
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2022 о.д. 25 № 49

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙНЦАГААН  
СУМЫН ГОВИЙН ИРЭЭДҮЙ  
ЦОГЦОЛБОР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Г.МЯГМАРСҮРЭН ТАНАА**

**Сөрөг дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Сайнцагаан сумын Говийн ирээдүй цогцолбор сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөний улмаас Сайнцагаан сумын Говийн ирээдүй цогцолбор сургуулийн 20.21 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар залруулагдаагүй буюу сургуулийн ажилтнуудад ажлын хувцас захиалахдаа төсвийн хэмнэлтийн горимыг зөрчин, барилгын материалын дэлгүүрээр дамжуулан 3,000.0 мянган төгрөгийг бэлнээр гарган авч, жилийн эцсийн тооллогоор биетээр байхгүй хувцсыг байгаагаар тоолж, баталгаажуулсан, албан хаагчдын ээлжийн амралтын цалинг илүү тооцон олгож, нийгмийн даатгалын тайланд зөрүүтэй тайлагнасан зэрэг зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т *Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 *Үнэн зөв байх*, 13.7-д *Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*, 20 дугаар зүйлийн 20.2.3-т *Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах*, 20.2.6-д *Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*, Нийгмийн даатгалын тухай хуулийн 17.1.-д *Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх*; заасныг тус тус зөрчсөн.

Залруулагдаагүй алдаа нь урьдчилан тооцоолсон материаллаг байдлын түвшнээс 1.9 дахин их, оршин байх, үнэлгээ ба хуваарилалт, эрх үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

0012020800

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)</b>	<b>144,532,874.99</b>	<b>160,090,544.29</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>		<b>13,949,800.00</b>
33500	Бусад авлага		13,949,800.00
33510	Байгууллагаас авах авлага		13,949,800.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>144,532,874.99</b>	<b>146,140,744.29</b>
35100	Түүхий эд материал	59,660,141.28	62,367,641.28
35110	Тусгай зориулалттай материал	59,359,701.28	62,078,401.28
35130	Эм боох материал	300,440.00	289,240.00
35400	Хангамжийн материал	84,872,733.71	83,773,103.01
35410	Бичиг хэргийн материал	2,220,494.00	3,319,494.00
35420	Аж ахуйн материал	78,269,615.71	72,964,569.01
35450	Барилгын засварын материал	2,905,000.00	5,011,300.00
35460	Хүнсний материал	1,477,624.00	2,477,740.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)</b>	<b>1,963,845,477.51</b>	<b>1,531,939,135.87</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,963,845,477.51</b>	<b>1,531,939,135.87</b>
39200	Биет хөрөнгө	1,855,017,477.40	1,423,111,135.87
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,473,904,750.82	1,426,146,750.82
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	(1,975,282,442.94)	(246,378,065.46)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	3,000,000.00	35,890,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл	(3,000,000.00)	(3,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	269,267,174.66	271,187,174.66
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(111,521,932.27)	(189,410,922.30)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	185,712,442.51	185,712,442.51
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(44,288,129.39)	(117,571,505.80)
39217	Номын фонд	57,225,614.01	60,535,261.44
39300	Биет бус хөрөнгө	108,828,000.11	108,828,000.00
39301	Програм хангамж	1,542,500.00	1,542,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж	(1,542,499.89)	(1,542,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	108,828,000.00	108,828,000.00

<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)</b>	<b>2,108,378,352.50</b>	<b>1,692,029,680.16</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)</b>		<b>14,184,372.02</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>14,184,372.02</b>
41300	Өглөг		14,184,372.02
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		14,183,572.02
41312	НДШ-ийн өглөг		6,604,858.77
41313	ХАОАТ-ын өглөг		7,578,713.25
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг		800.00
413201	Бичиг хэргийн өглөг		800.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)</b>	<b>2,108,378,352.50</b>	<b>1,677,845,308.14</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>2,108,378,352.50</b>	<b>1,677,845,308.14</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,695,912,859.14	1,695,912,859.14
51200	Хуримтлагдсан үр дүн	(621,430,105.25)	(1,051,963,149.61)
51210	Өмнөх үеийн үр дүн	(621,430,105.25)	(621,430,105.25)
51220	Тайлант үеийн үр дүн		(430,533,044.36)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,033,895,598.61	1,033,895,598.61
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)</b>	<b>2,108,378,352.50</b>	<b>1,692,029,680.16</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,172,352,237.18</b>	<b>1,802,565,351.43</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>286,527,437.18</b>	<b>40,619,647.43</b>
1200	Нийтлэг татварын бус орлого	286,527,437.18	40,619,647.43
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		630,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого		630,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	267,930,796.07	38,119,647.43
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Материал	18,596,641.11	1,870,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,885,824,800.00</b>	<b>1,761,945,704.00</b>
1310	Улсын төсвөөс	1,598,095,600.00	1,491,944,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,598,095,600.00	1,491,944,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	150,000.00	15,078,804.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	150,000.00	15,078,804.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	287,579,200.00	254,922,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	287,579,200.00	254,922,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>2,006,250,729.26</b>	<b>1,994,899,941.42</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,006,250,729.26</b>	<b>1,994,899,941.42</b>
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,894,065,777.65	1,959,880,675.07
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,261,861,414.00	1,233,458,452.50
210101	Үндсэн цалин	784,674,188.00	782,590,669.66
210102	Нэмэгдэл	360,829,562.00	351,596,635.62
210104	Урамшуулал	116,357,664.00	99,271,147.22
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	158,785,805.39	165,309,784.24
210201	Тэтгэврийн даатгал	108,356,522.16	121,207,162.51
210202	Тэтгэмжийн даатгал	12,710,175.20	11,085,540.96
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,161,419.54	8,868,313.16
210204	Ажилгүйдлийн даатгал	2,518,043.40	2,196,129.06
210205	Эрүүл мэндийн даатгал	25,039,645.09	21,952,638.55
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	275,806,561.00	230,090,615.23
210301	Гэрэл, цахилгаан	9,129,255.00	9,202,909.23
210302	Түлш, халаалт	250,785,650.00	196,849,706.00
210303	Цэвэр, бохир ус	15,891,656.00	24,038,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,227,453.00	26,669,424.40
210401	Бичиг хэрэг	3,723,050.00	2,069,800.00
210402	Тээвэр, шатахуун	658,488.00	787,372.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	884,029.00	2,747,289.70
210404	Ном, хэвлэл	105,000.00	789,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	651,096.00	866,096.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,205,790.00	19,409,666.70
2105	Нормативт зардал	28,208,626.00	34,077,364.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	265,680.00	1,427,880.00
210502	Хоол, хүнс	27,309,096.00	32,354,284.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	633,850.00	295,200.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,434,250.00	25,370,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		2,980,000.00
210604	Урсгал засвар	11,434,250.00	22,390,700.00
2107	Томилолт, зочны зардал	312,000.00	
210702	Дотоод албан томилолт	312,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,575,800.00	9,625,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,143,800.00	9,385,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	141,853,868.26	240,299,334.70
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		4,806,100.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	1,339,900.00	3,665,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	140,513,968.26	231,827,534.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	112,184,951.61	29,998,666.35
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,689,500.00	27,325,735.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	18,988,000.00	23,207,735.00
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	95,200.00	518,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,606,300.00	3,600,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,932,389.00	21,238.77
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,932,389.00	21,238.77
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	86,563,062.61	2,651,692.58
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	86,563,062.61	2,651,692.58
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)</b>	<b>166,101,507.92</b>	<b>(192,334,589.99)</b>
<b>5</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)</b>		<b>238,198,454.37</b>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ		238,198,454.37
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		238,198,454.37
<b>6</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)</b>	<b>166,101,507.92</b>	<b>(430,533,044.36)</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,695,912,859.14	1,033,895,598.61	(787,531,613.17)	1,942,276,844.58

3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,695,912,859.14	1,033,895,598.61	(787,531,613.17)	1,942,276,844.58
7	Өмчид гарсан өөрчлөлт			166,101,507.92	166,101,507.92
8	Зарласан ноогдол ашиг	1,695,912,859.14	1,033,895,598.61	(621,430,105.25)	2,108,378,352.50
11	<b>2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>1,695,912,859.14</b>	<b>1,033,895,598.61</b>	<b>(621,430,105.25)</b>	<b>2,108,378,352.50</b>
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,695,912,859.14	1,033,895,598.61	(621,430,105.25)	2,108,378,352.50
19	<b>Тайлант үеийн үр дүн</b>			<b>(430,533,044.36)</b>	<b>(430,533,044.36)</b>
20	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,695,912,859.14</b>	<b>1,033,895,598.61</b>	<b>(1,051,963,149.61)</b>	<b>1,677,845,308.14</b>

#### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,885,824,800.00</b>	<b>1,762,575,704.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>		<b>630,000.00</b>
1200	Нийтлэг татварын бус орлого		630,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		630,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого		630,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,885,824,800.00</b>	<b>1,761,945,704.00</b>
1310	Улсын төсвөөс	1,598,095,600.00	1,491,944,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,598,095,600.00	1,491,944,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	150,000.00	15,078,804.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	150,000.00	15,078,804.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	287,579,200.00	254,922,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	287,579,200.00	254,922,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)</b>	<b>1,883,659,700.00</b>	<b>1,762,575,704.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,883,659,700.00</b>	<b>1,762,575,704.00</b>
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,773,565,438.39	1,720,772,827.65
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,261,861,414.00	1,225,879,739.25
210101	Үндсэн цалин	784,674,188.00	775,011,956.41
210102	Нэмэгдэл	360,829,562.00	351,596,635.62
210104	Урамшуулал	116,357,664.00	99,271,147.22
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	158,785,805.39	158,704,925.47

210201	Тэтгэврийн даатгал	108,384,684.40	114,602,303.74
210202	Тэтгэмжийн даатгал	12,710,175.20	11,085,540.96
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,161,419.54	8,868,313.16
210204	Ажилгүйдлийн даатгал	2,489,881.16	2,196,129.06
210205	Эрүүл мэндийн даатгал	25,039,645.09	21,952,638.55
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	275,806,561.00	230,090,615.23
210301	Гэрэл, цахилгаан	9,129,255.00	9,202,909.23
210302	Түлш, халаалт	250,785,650.00	196,849,706.00
210303	Цэвэр, бохир ус	15,891,656.00	24,038,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,730,343.00	11,147,227.70
210401	Бичиг хэрэг	574,800.00	1,815,900.00
210402	Тээвэр, шатахуун	658,488.00	787,372.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	884,029.00	2,747,289.70
210404	Ном, хэвлэл	105,000.00	874,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	658,596.00	1,506,946.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,849,430.00	3,415,520.00
2105	Нормативт зардал	31,821,765.00	27,751,520.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	395,020.00	1,056,330.00
210502	Хоол, хүнс	22,086,545.00	23,695,190.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,340,200.00	3,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,840,250.00	47,426,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		22,599,200.00
210604	Урсгал засвар	8,840,250.00	24,827,000.00
2107	Томилолт, зочны зардал	312,000.00	
210702	Дотоод албан томилолт	312,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,575,800.00	9,320,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,143,800.00	9,080,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,831,500.00	10,452,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		4,700,000.00

210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	13,831,500.00	5,752,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	110,094,261.61	41,802,876.35
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,598,810.00	39,129,945.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,897,310.00	32,866,945.00
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	95,200.00	518,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,606,300.00	5,745,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,932,389.00	21,238.77
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,932,389.00	21,238.77
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	86,563,062.61	2,651,692.58
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	86,563,062.61	2,651,692.58
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)</b>	<b>2,165,100.00</b>	
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>		
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>		
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)</b>		
<b>9</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>		
<b>10</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>		
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)</b>		
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)</b>	<b>2,165,100.00</b>	
<b>14</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>15</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>11000</b>	<b>Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл</b>		
<b>11100</b>	<b>Үүнээс: Банкин дахь харилцах дансны үлдэгдэл</b>		
<b>11200</b>	<b>Кассын оны эхний үлдэгдэл</b>		
<b>12</b>	<b>Татварын бус орлого</b>	<b>1,746,866,900.00</b>	<b>1,744,210,822.65</b>
122005	Төсвөөс санхүүжих	254,922,000.00	254,917,615.23
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	1,491,944,900.00	1,489,293,207.42
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,746,866,900.00</b>	<b>1,744,727,322.65</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,746,866,900.00</b>	<b>1,744,727,322.65</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,707,709,500.00</b>	<b>1,705,597,377.65</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,226,472,000.00</b>	<b>1,225,879,739.25</b>

210101	Үндсэн цалин	775,145,000.00	775,011,956.41
210102	Нэмэгдэл	351,674,400.00	351,596,635.62
210104	Урамшуулал	99,652,600.00	99,271,147.22
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>159,155,600.00</b>	<b>158,704,925.47</b>
210201	Тэтгэврийн даатгал	114,743,800.00	114,602,303.74
210202	Тэтгэмжийн даатгал	11,095,200.00	11,085,540.96
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,870,000.00	8,868,313.16
210204	Ажилгүйдлийн даатгал	2,223,200.00	2,196,129.06
210205	Эрүүл мэндийн даатгал	22,223,400.00	21,952,638.55
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>230,095,000.00</b>	<b>230,090,615.23</b>
210301	Гэрэл, цахилгаан	9,205,200.00	9,202,909.23
210302	Түлш, халаалт	196,849,800.00	196,849,706.00
210303	Цэвэр, бохир ус	24,040,000.00	24,038,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>8,331,500.00</b>	<b>7,932,377.70</b>
210401	Бичиг хэрэг	1,062,700.00	1,062,400.00
210402	Тээвэр, шатахуун	860,000.00	787,372.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,497,600.00	1,497,289.70
210404	Ном, хэвлэл	813,700.00	809,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,307,500.00	991,596.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,790,000.00	2,784,020.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>28,076,600.00</b>	<b>27,751,520.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,075,700.00	1,056,330.00
210502	Хоол, хүнс	23,750,100.00	23,695,190.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,250,800.00	3,000,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>44,446,400.00</b>	<b>44,446,200.00</b>
210601	Багаж, техник хэрэгсэл	19,619,400.00	19,619,200.00
210604	Урсгал засвар	24,827,000.00	24,827,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>340,400.00</b>	
210702	Дотоод албан томилолт	340,400.00	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнийн төлбөр, хураамж</b>	<b>1,740,000.00</b>	<b>1,740,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,500,000.00	1,500,000.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	240,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>9,052,000.00</b>	<b>9,052,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,700,000.00	4,700,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,352,000.00	4,352,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>39,157,400.00</b>	<b>39,129,945.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	32,884,400.00	32,866,945.00
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	528,000.00	518,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,745,000.00	5,745,000.00
<b>3</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>516,500.00</b>
<b>30</b>	<b>Нэр данс, зөрүү, төсөл хөтөлбөрийн орлого</b>		<b>516,500.00</b>
300004	Тендерийн орлогоос зөвхөн тендер зохион байгуулахтай холбогдсон урсгал зардал		516,500.00
<b>12000</b>	<b>Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		
<b>12100</b>	<b>Үүнээс: Банкин дахь харилцах дансны үлдэгдэл</b>		
<b>12200</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>254,922,000.00</b>	<b>254,917,615.23</b>
<b>12200</b>	<b>Кассын дансны эцсийн үлдэгдэл</b>		

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (I)</b>	<b>15,078,804.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>15,078,804.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>15,061,950.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3,101,350.00</b>
210401	Бичиг хэрэг	640,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,250,000.00
210404	Ном, хэвлэл	64,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	515,350.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	631,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,980,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,980,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>7,580,600.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,580,600.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,400,000.00</b>
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	1,400,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>16,854.00</b>

2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>16,854.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,854.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР (II)</b>	<b>15,078,804.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>15,078,804.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>15,078,804.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	15,078,804.00
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
<b>11000</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>12000</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дундговь аймгийн Сайнцагаан сумын Говийн ирээдүй цогцолбор сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Должинсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал, газрын дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Сайнцагаан сумын Говийн ирээдүй цогцолбор сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 06-ний өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Дундговь аймгийн Сайнцагаан сумын Говийн ирээдүй цогцолбор сургууль нь эрхэм зорилгоо “Хүн амд эрүүл мэндийн боловсрол тасралтгүй олгох замаар хүн амын дундах өвчлөлийг бууруулж эрүүлжилтийн түвшнийг дээшлүүлэхэд оршино” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2021 оны 06 сар хүртэлх санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийн, 9 зөвлөмж хүргүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дундговь аймгийн Сайнцагаан сумын Говийн ирээдүй цогцолбор сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн

зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 4 дүгээр улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны 4 дүгээр улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,973,994.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 19,739.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлын 70 хувиар буюу 13,817.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд сургуулийн албан хаагчдын цалин, нийгмийн даатгалын зардлыг 25,440.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасанг залруулга хийж, санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 1,999,434.8 мянган төгрөг болсон. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,999,434.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 19,994.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлын 70 хувиар буюу 13,996.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Дундговь аймгийн Сайнцагаан сумын Говийн ирээдүй цогцолбор сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 420,883.5 мянган төгрөгөөр буюу 19.9 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан хөрөнгийн данс нь эргэлтийн хөрөнгийн данс бөгөөд 2,047,758.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй сургуулийн хичээлийн нэгдүгээр байрыг акталсан нь нөлөөлсөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	144,532.9	160,090.5	15,557.7
АВЛАГА	-	13,949.8	13,949.8
БАРАА МАТЕРИАЛ	144,532.9	146,140.7	1,607.9
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	1,963,845.5	1,527,404.3	(436,441.2)
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,963,845.5	1,527,404.3	(436,441.2)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	2,108,378.4	1,687,494.8	(420,883.5)
НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)		14,184.4	14,184.4
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		14,184.4	14,184.4
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	2,108,378.4	1,673,310.4	(435,067.9)
Засгийн газрын хувь оролцоо	2,108,378.4	1,673,310.4	(435,067.9)
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	2,108,378.4	1,687,494.8	(420,883.5)

Бараа материал дансны үлдэгдэл 146,140.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,607.9 мянган төгрөгөөр өссөн нь түүхий эд материалын дансны өсөлт байна.

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд 32,890.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 1,920.0 мянган төгрөгийн тавилга тоног төхөөрөмж, 3,309.6 мянган төгрөгийн хөрөнгийг дээд шатны байгууллагаас хандиваар авсан байна. Мөн 2,047,758.0 мянган төгрөгийн барилгыг данснаас хассан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,673,310.4 мянган төгрөг болж 420,883.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүн буурснаас шалтгаалжээ.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,773,123.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,773,123.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 26,256.3 мянган төгрөгөөр өсгөн 1,746,866.9 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн бууралт нь цар тахлын үеийн хичээл цахимд шилжсэнтэй холбоотойгоор үдийн цай болон байрны хоолны мөнгийг бууруулсантай холбоотой.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 1,746,866.9 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,746,866.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд нийт төсвийн 99.8% хувийг зарцуулж, 2,656.1 мянган төгрөгийг улсын болон орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,744,210.8 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь цалин хөлс болон ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын гүйцэтгэл буюу батлагдсан орон тооноос дутуу, бусад зардлын хэмнэлттэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд төсвийн дээд шатны байгууллагаас 10,462.0 мянган төгрөгийн номын түрээсийн санхүүжилт, аймгийн Боловсролын газраар дамжин “Хүүхдэд ээлтэй ертөнц төсөл”-ийн үлдэгдэл 4,616.8 мянган төгрөгийн санхүүжилт нийт 15,078.8 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлжээ.

Үүнээс төслийн үйл ажиллагааны зардалд 4,600.0 мянган төгрөгийг хичээлийн хэрэглэгдэхүүн, сургалтын зардалд, номын түрээсийн төлбөрт 10,462.0 мянган төгрөгийг зарцуулж, 16.8 мянган төгрөгийг улсын орлогод буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд дараах онцлох асуудлууд байна. Үүнд:

1. Дундговь аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас 32,890.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг шилжүүлэн өгсөн байна.
2. Сургуулийн хичээлийн 2,047,758.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй сургуулийн барилгыг актлан, буулгаж, шинэ сургуулийн барилгын ажил эхэлсэн байна.
3. Сургуулийн сурагчдын дотуур байрны халаалтын төлбөрийг м.куб-ээр тооцож олгосныг 2022 оноос м.кв-аар тооцуулахаар шийдвэрлэсэн.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй буюу сургуулийн ажилтнуудад ажлын хувцас захиалахдаа төсвийн хэмнэлтийн горимыг зөрчин, барилгын материалын дэлгүүрээр дамжуулан 3,000.0 мянган төгрөгийг бэлнээр гарган авч, жилийн эцсийн тооллогоор биетээр байхгүй хувцсыг байгаагаар тоолон, баталгаажуулсан, албан хаагчдын ээлжийн амралтын цалинг илүү тооцон олгож, 18,798.8 мянган төгрөгийн цалингийн зардлыг нийгмийн даатгалын тайланд дутуу тайлагнасан зэрэг зөрчлүүд нь аудитын гол асуудал байна гэж үзлээ.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дундговь аймгийн Сайнцагаан сумын Говийн ирээдүй цогцолбор сургууль нь 2021 онд нийт 2,248,449.9 мянган төгрөгийн 165 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод, бүрэн байршуулахаас 2 мэдээллийг хугацаа хоцроож, хэрэгжилт 91.0 хувьтай байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, Эрчим хүчний зохицуулах хорооны тогтоол зөрчсөн 2,435.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

Сургуулийн дотуур байрны халаалтын төлбөрийг төсөв, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын халаалтын тарифаар тооцон шилжүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар хөрөнгийн асуудлаар 1 зөвлөмж, ажилчдад олгосон түлшний хөнгөлөлттэй холбоотой 1 төлбөрийн акт, шилэн дансны аудитаар 1 албан шаардлага хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан үндсэн хөрөнгө, бараа материалын дансанд завсрын аудитаар хяналтын тооллого хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 44,528.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 18,097.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 5,196.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 21,234.6 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Эрх бүхий албан тушаалтны буруутай шийдвэрээр ажлаас халагдан, ажилгүй байсан хугацааны НДШ-д 3,000.0 мянган төгрөг төлснийг шууд зардлаар тайлагнасан;
2. Гамшгаас хамгаалах арга хэмжээнд төвлөрүүлсэн 1,700.0 мянган төгрөгийг зардлыг үр дүнгийн тайланд буруу тайлагнасан;
3. Цалингийн зардлыг үр дүнгийн тайланд 5,818.6 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан;
4. ХХОАТ-ийн 7,578.7 мянган төгрөгийн өр төлбөрийг санхүүгийн тайланд тусгаагүй.

*Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад 18,097.3 мянган төгрөгийн алдааг залруулсан.*

### 4.2 Төлбөрийн акт

Аудитаар нийт 5,196.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. Сургуулийн захирал ээлжийн амралтаараа төрсөн нутагтаа очиж амрах замын зардалд 165.4 мянган төгрөгийг илүү олгосон;
2. Сургуулийн 58 ажилчдын ээлжийн амралтын олговрыг 2,031.3 мянган төгрөгийн зөрүүтэй тооцож олгосон;
3. Ажилтнуудад ажлын хувцас захиалахдаа барилгын материалын дэлгүүрээр дамжуулан 3,000.0 мянган төгрөгийг бэлнээр гарган авч, жилийн эцсийн тооллогоор биетээр байхгүй хувцсыг байгаагаар тоолж, баталгаажуулсан.

*Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.*

### 4.3 Албан шаардлага

Аудитаар нийт 21,234.6 мянган төгрөгийн зөрчилд хугацаатай албан шаардлага хүргүүлээ.

Үүнд:

1. Сургуулийн дотуур байрны халаалтын төлбөрийг төсөв, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын халаалтын тарифаар тооцон шилжүүлсэн;
2. Төсвийн хэмнэлтийн горимыг зөрчин шагнал, урамшуулал, уралдаан тэмцээнд 2,435.7 мянган төгрөгийг зарцуулсан;
3. Сургуулийн 67 албан хаагчийн цалинг нийгмийн даатгалын тайланд 18,798.8 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.

*Шийдвэрлэсэн нь: Хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.*

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/Мянган төгрөгөөр/

д/ д	Алдаа, зөрчлийн агуулга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>1. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд:</b>											
1	Төсвийн хэмнэлтийн горимыг зөрчин шагнал, урамшуулал, уралдаан тэмцээнд 2,435.7 мянган төгрөгийг зарцуулсан	1	2,435.7					1	2,435.70		
2	Сургуулийн дотуур байрны халаалтын төлбөрийг төсөв, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын халаалтын тарифаар тооцон шилжүүлсэн;	1	-					1			
	Дүн	2	2,435.7					2	2,435.70		
<b>2. Бусад батламж мэдэгдлийн хүрээнд:</b>											
1	Эрх бүхий албан тушаалтны буруутай шийдвэрээр ажлаас халагдан, ажилгүй байсан хугацааны НДШ-д 3,000.0 мянган төгрөг төлснийг шууд зардлаар тайлагнасан	1	3,000.0	1	3,000.0						
2	Гамшгаас хамгаалах арга хэмжээнд төвлөрүүлсэн 1,700.0 мянган төгрөгийг зардлыг үр дүнгийн тайланд буруу тайлагнасан	1	1,700.0	1	1,700.0						
3	Цалингийн зардлыг үр дүнгийн тайланд 5,818.6 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан	1	5,818.6	1	5,818.6						
4	ХХОАТ-ийн 7,578.7 мянган төгрөгийн өр төлбөрийг санхүүгийн тайланд тусгаагүй	1	7,578.7	1	7,578.7						
5	Сургуулийн захирал ээлжийн амралтаараа төрсөн нутагтаа очиж амрах замын зардалд 165.4 мянган төгрөгийг илүү олгосон	1	165.4			1	165.4				
6	Сургуулийн 58 ажилчдын ээлжийн амралтын мөнгийг 2,031.3 мянган төгрөгийн зөрүүтэй тооцож олгосон	1	2,031.3			1	2,031.3				
7	Ажилтнуудад ажлын хувцас захиалахдаа барилгын материалын дэлгүүрээр дамжуулан 3,000.0 мянган төгрөгийг бэлнээр гарган авч, жилийн эцсийн тооллогоор биетээр байхгүй хувцсыг байгаагаар	1	3,000.0			1	3,000.0				

	тоолж, баталгаажуулсан										
8	Сургуулийн 67 албан хаагчийн цалинг нийгмийн даатгалын тайланд 18,798.8 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан	1	18,798.8					1	18,798.8		
	Дүн	8	42,092.8	4	18,097.3	3	5,196.7	1	18,798.8	-	-
	Нийт дүн	10	44,528.5	4	18,097.3	3	5,196.7	3	21,234.5	-	-